



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/36/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК Захирал А.Сарангэрэл Утас: 99884842 Цахим хаяг: Gereltekhhburtgelaudit02@gmail.com Ахлах аудитор: Д.Галт-Эрдэнэ Утас: 80085430 Цахим хаяг: Gereltekhhburtgelaudit02@gmail.com Аудитор С.Дашдэндэв Утас: 80099418 Цахим хаяг: Gereltekhhburtgelaudit02@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 03.15 № 479
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР ДЭВШИЛ
МЕНЕЖМЕНТ ААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ГАНХУЯГ
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд Сүхбаатар дүүргийн 4 хорооны 624 аж ахуйн нэгж байгууллага, гэр хорооллын 2,896 айл өрхийн, орон сууцны 1,516 айл өрхийн хог хаягдлыг хог тээврийн 8 машинаар 5,528 рейсийн 18,609 тонн жингээр Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	100,685,827.93	183,723,541.39
1.1.2	Дансны авлага	19,152,423.00	40,180,500.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	219,617.19	
1.1.6	Бараа материал	28,889,826.88	59,136,992.72
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	148,947,695.00	283,041,034.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	337,796,078.67	1,545,446,186.91
1.2.2	Биет бус хөрөнгө	35,432,641.11	35,738,356.16
1.2.3	Дуусаагүй барилга	-	21,105,221.23
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	373,228,719.78	1,602,289,764.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	522,176,414.78	1,885,330,798.41
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	1,347,500.00	-
2.1.1.3	Татварын өр	2,174,662.32	23,840,107.19
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	357,242,931.93	313,775,392.25
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	360,765,094.25	337,615,499.44
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5	Хойшлогдсон орлого	-	1,162,654,613.70
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	1,162,654,613.70
2.2	Өр төлбөрийн нийт дүн	360,765,094.25	1,500,270,113.14
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч:-төрийн	-	-
2.3.2	хувийн	-	-
2.3.3	хувьцаат	-	-
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	11,000,000.00
2.3.5	Хуримтлагдсан ашиг	161,411,320.53	374,060,685.27
2.3.6	Эздийн өмчийн дүн	161,411,320.53	385,060,685.27
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	522,176,414.78	1,885,330,798.41

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	258,665,887.08	1,127,924,935.54
2	Борлуулалтын өртөг	440,000.00	
3	Нийт ашиг(алдагдал)	258,225,887.08	1,127,924,935.54
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	428,571,782.17	1,050,123,997.14
9	Борлуулалт, маркетингийн зардал	496,098,894.92	1,651,755,882.46
10	Ерөнхий ба удирдлагын зардал	170,958,651.08	260,949,939.19
11	Санхүүгийн зардал		

Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

12	Бусад зардал	117,500.00	29,066,039.10
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	19,622,623.25	236,277,071.93
19	Орлогын татварын зардал	1,962,262.32	23,627,707.19
20	Татварын дараах ашиг (алдагдал)	17,660,360.93	212,649,364.74
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	17,660,360.93	212,649,364.74
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	17,660,360.93	212,649,364.74
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	143,169,224.44	143,169,224.44
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	18,242,096.09	18,242,096.09
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-
7	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	161,411,320.53	161,411,320.53
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	212,649,364.74	212,649,364.74
11	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,000,000.00	-	11,000,000.00
12	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
13	Зарласан ногдол ашиг	-	-	-
14	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,000,000.00	374,060,685.27	385,060,685.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	639,349,908.08	1,932,252,646.54
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	253,271,417.08	1,104,739,435.54
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	--
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,882,491.00	4,859,961.00
	Буцаан авсан албан татвар		-
	Татаас, санхүүжилтийн орлого	384,196,000.00	815,000,000.00
	Бусад мөнгөн орлого	-	7,653,250.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	610,523,149.96	1,763,234,433.08

**Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан**

	Ажиллагчдад төлсөн	302,684,606.84	1,077,033,057.45
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	40,484,682.55	139,997,167.39
	Бараа материал худалдан авахад төлсөн	45,012,173.66	172,200,252.00
	Ашиглалтын зардалд төлсөн	7,882,122.38	19,749,821.53
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	195,421,465.54	283,471,086.65
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	614,900.00	3,175,397.32
	Даатгалын төлбөрт төлсөн	2,630,660.16	18,194,413.00
	Бусад мөнгөн зарлага	15,792,538.83	49,413,237.74
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	28,826,758.12	169,018,213.46
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,589,800.00	85,980,500.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,149,800.00	84,550,500.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	440,000.00	1,430,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-6,589,800.00	-85,980,500.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	22,236,958.12	83,037,713.46
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	78,448,869.81	100,685,827.93
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	100,685,827.93	183,723,541.39

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
А	Аж ахуйн нэгжийн хог хаягдлын хураамжийн орлого	217,597,500.00	554,406,319.00	594,282,978.00	39,876,658.65	107.0
	Хэрэглэгчдэд үйлчлэх төв /орон сууц/	7,182,480.00	34,264,800.00	31,531,000.00	-2,733,800.00	92.0
	Гэр хороолол	33,885,907.00	66,778,624.00	59,594,185.00	-7,184,439.46	89.0
	Зам талбайн цэвэрлэгээ 6,9,14,16 хороо орлого	-	389,364,773.00	389,364,773.00	-	100.0
	Иргэдийн бүлгийн гүйцэтгэл	-	53,152,000.00	53,152,000.00	-	100.0
Б	Татаас санхүүжилт	341,796,000.00	861,000,000.00	785,000,000.00	-76,000,000.00	91.0

Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

B	Зах-А/503 Өвөлжилтийн бэлтгэл ажлын санхүүжилт	42,400,000.00	-	30,000,000.00	30,000,000.00	91.0
	Бусад орлого	44,375,782.00	235,123,997.00	235,123,997.00	-	100.0
	Нийт орлогын дүн	687,237,669.25	2,194,090,513.49	2,178,048,932.68	16,041,580.81	99.12
	Цалин хөлс	120,000,000.00	455,124,000.00	453,281,264.00	1,842,736.00	99.6
	Цалингийн нэмэгдэл, урамшуулал	182,684,607.00	604,509,655.33	604,412,255.33	97,400.00	100.0
	Нийгмийн даатгалын шимтгэл	40,484,683.00	140,147,817.00	139,997,167.00	150,650.00	99.9
	Албан татвар хураамж /Машины татвар бусад/		3,500,000.00	1,584,835.00	1,915,165.00	45.3
	Бичиг хэргийн зардал	2,846,590.00	4,800,000.00	5,137,810.00	-337,810.00	107.0
	Ашиглалтын зардал	7,882,122.00	19,500,000.00	19,549,821.00	-49,821.00	100.3
	Хангамжийн материалын зардал	4,100,000.00	32,000,000.00	32,648,650.00	-648,650.00	102.0
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал	13,705,538.00	15,000,000.00	15,822,126.00	-822,126.00	105.5
	Сургалтын зардал		0.00	0.00	-	00.0
	Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/	28,166,601.00	0.00	0.00	-	00.0
	Тогтмол үйлчилгээ, засварын зардал	10,739,070.00	39,000,000.00	39,325,354.00	-325,354.00	100.8
	Шатахууны зардал	119,890,150.00	221,619,360.00	218,613,202.00	3,006,158.00	98.6
	Даатгалын зардал	2,630,660.00	19,000,000.00	18,156,997.00	843,003.00	95.6
	Утас, интернэтийн зардал	865,370.00	1,320,000.00	1,280,331.00	39,669.00	97.0
	Томилолтын зардал /унаа, буудал, хоол/	6,800,000.00	27,000,000.00	26,720,000.00	280,000.00	99.0
	Хэвлэлийн зардал		2,000,000.00	2,449,700.00	-449,700.00	122.5
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	1,100,000.00	19,000,000.00	18,760,000.00	240,000.00	98.7
	Банкны үйлчилгээний зардал		550,000.00	116,933.00	433,067.00	21.3
	Цэвэрлэгээний материалын зардал	3,037,992.00	15,400,000.00	15,010,778.00	389,222.00	97.5
	бусад зардал		29,066,039.10	29,066,039.10	-	100.0
	Элэгдэл,хорогдлын зардал	44,375,782.17	180,424,676.32	180,424,676.32	-	100.0
	Хөдөлмөр хамгааллын зардал	7,725,100.00	36,260,000.00	36,199,600.00	60,400.00	99.8
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	10,268,538.00	22,000,000.00	20,634,556.00	1,365,444.00	98.9
	Сэлбэг хэрэгслийн зардал	46,716,714.00	59,000,000.00	60,717,484.00	-1,717,484.00	102.9
	Онцгой байдлын зардал	879,414.00	3,000,000.00	1,862,282.00	1,137,718.00	62.1
	Нийт зардлын дүн	654,898,931.17	1,949,221,547.75	1,941,771,860.75	7,449,687.00	99.6
	Цэвэр ашиг/алдагдал	17,660,360.93	289,975,700.00	212,649,364.74	77,326,335.26	73.3
	Хөрөнгө оруулалт	185,000,000.00	150,000,000.00	146,878,200.00	3,121,800.00	97.9

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 1,291,400.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газраас үнэ төлбөргүй шилжин ирсэн 1,291,400.0 мянган төгрөгийн 4 ширхэг хог тээврийн тусгай зориулалтын автомашиныг санхүүгийн тайланд хойшлогдсон орлого дансанд тусад нь толилуулаагүй. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын 2 дугаар бүлгийн 2.2.7-д заасан "Аж ахуйн нэгж нь үнэ төлбөргүйгээр буюу буцалтгүй тусламж, бэлэг, хандиваар үндсэн хөрөнгийг олж бэлтгэсэн бол хүлээн авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, тайлант үеийн орлого/хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрнө", НББОУС 20-ын "Засгийн газрын туслалцаа, буцалтгүй тусламж"-д заасан аргуудаас сонгон хэрэглэж болно" заалт, Засгийн газрын туслалцаа, буцалтгүй тусламж НБББОУС 20-ийн "Хөрөнгөтэй холбоотой буцалтгүй тусламж" хэсэгт тодорхойлсон "Бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус буцалтгүй тусламжийг багтаасан хөрөнгөтэй холбоотой Засгийн газрын буцалтгүй тусламжийг хойшлогдсон орлого хэлбэрээр эсвэл ,, хэлбэрийн аль нэгээр балансад толилуулна", гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 6,790.9 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 4,160.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,630.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 6,790.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,600.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Автомашинд хохирол учруулсан 4,160.0 мянган төгрөгийн хохирлыг байгууллагын хөрөнгөнөөс гаргаж, засвар үйлчилгээний зардлаар бүртгэж тайлагнан, буруутай этгээдээр хохирлыг барагдуулахаар авлага үүсгэж бүртгээгүй байгаа нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4 заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулан бол гэм хорыг арилган байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардан гаргуулах эрхтэй", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт-1: Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын дэргэдэх ТУЗ-ийн баталсан зорилтот түвшний төлөвлөгөөгөөр зориулалтын давс тусгай бодисыг төлөвлөж, батлуулаагүй, гүйцэтгэлээр тайлант онд СБД-ийн Засаг даргын тамгын газраас давс тусгай бодисын санхүүжилт олгож, үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв тооцоолж орлого, гүйцэтгэлийг оновчтой уялдуулан төлөвлөх, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх

Илрүүлэлт-2: Нийт 45 байгууллага, 6 хувь хүнтэй холбоотой 2,630.9 мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн И баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “*Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 “*бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно*”, 17.6 “*Албан татвар суутгаан төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй*” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “*иж бүрэн байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийх тухай бүрд И баримтаар баталгаажуулж байх, татварын хууль тогтоомжийг мөрдөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хойшлогдсон орлого дансыг санхүүгийн тайланд толилуулаагүй	1	1,291,400.0	1	1,291,400.0	-	-	1	1,291,400.0	-	-	-	-
Дүн	1	1,291,400.0	1	1,291,400.0	-	-	1	1,291,400.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр зориулалтын давс тусгай бодисыг төлөвлөж, батлуулаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Худалдан авалтыг төлбөрийн И баримтаар баталгаажуулаагүй	1	2,630.9	-	-	-	-	1	2,630.9	-	-	-	-
Автомашин хохирлыг буруутай этгээдээр төлүүлээгүй	1	4,160.0	1	4,160.0	-	-	-	-	-	-	-	-
Дүн	3	6,790.9	1	4,160.0	-	-	2	2,630.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	496,504.8	-	-	1	496,504.8	-	-	-	-	-	-
Дүн	1	496,504.8	-	-	1	496,504.8	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил												

Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Автомашины улсын дугаарыг цэнхэр дэвсгэртэй болгоогүй	1	-	-	-	-	-	1	-
Хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй олж бэлтгэсэн	1	10,784.6	-	-	1	10,784.6	-	-
Дүн	2	10,784.6	-	-	1	10,784.6	1	-
Нийт дүн	3	507,289.4	-	-	2	507,289.4	1	-